

Оросын эдийн засаг: Өнөөгийн байдал, сорилт, гарц

Д.АЛТАЙ¹

Хураангуй: ОХУ-н эдийн засгийн өнөөгийн байдал, тулгарч буй сорилт бэрхшээл, хямралыг гэтлэх төлөвлөгөө, эдийн засгийг либералчлах, бүтцийн өөрчлөлт хийх цогц шинэчлэлийн шаардлагын тухай асуудлыг авч үзжээ. Украины хямралаас үүдэн барууны орнуудаас ОХУ-н эсрэг авч буй хориг арга хэмжээ, дэлхийн зах зээл дахь газрын тосны үнийн савалгаа, рублийн ханины сулрал, төсвийн алдагдал зэрэг хүчин зүйлүүдийн нөлөөллөөр Оросын эдийн засаг хямралт байдалд орсон. Хямралыг даван туулах ЗГ-н богино хугацааны төлөвлөгөөг ОХУ-д батлан хэрэгжүүлж байгаа ч энэ нь түр зуурын арга хэмжээ бөгөөд эдийн засгийн тогтвортой өсөлтийг ирээдүйд хангах гарц болж чадахгүй. Учир нь сүүлийн 20 гаруй жилд эдийн засгийн хямралт байдалд удаа дараа өртөж буй учир шалтгааныг ул суурьтай шинжилж, эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийн, иж бүрэн, төгс шинэчлэлийг хэрэгжүүлэх аваас Орос улс эдийн засгийн хувьд хүчирхэг хөгжингүй орнуудын түвшинд хүрнэ.

* * *

Сүүлийн 25 жилд ОХУ төр-эдийн засгийн гүнзгий хувьсгалыг хийж, хүчирхэг Зөвлөлт гүрэн задарснаар үндэсний төрт Орос улс сэргэн төвхнөх, ардчилсан төрийн тогтолцоог төлөвшүүлэх, төвлөрсөн төлөвлөгөөт аж ахуйгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг туулсан. ОХУ нь түүхий эд, ашигт малтмалаар баялаг, хүчирхэг эдийн засагтай бөгөөд 2013 оны Дэлхийн Банкны мэдээллээр нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 24120 ам.долларт хүрч, энэхүү үзүүлэлтээр дэлхийн 50 тэргүүлэгч орны тоонд багтаж, ТУХН-н (Тусгаар Улсуудын Хамтын

1. ШУА-ийн Олон Улсын Харилцааны Хүрээлэнгийн Дэлхийн бодлогын салбарын эрхлэгч, проф. Ph.D altai_macees@yahoo.com

Нийгэмлэг) орнуудаас хөгжлөөрөө тэргүүлж байна. Дэлхий дахины бодлого, олон улсын харилцаанд ОХУ нь чухал нөлөөтэй билээ. Орчин үед түүний байр суурь, хандлагаас олон улсын харилцааны хувьсан өөрчлөгдөж буй дэг журам ихээхэн шалтгаалж байна. Тиймээс ч Оросын бодлого нь түүний нийгэм-эдийн засгийн хөгжлийн асуудал судлаачдын анхаарлыг байнга татсаар ирсэн.

2014 оны хавраас өрнөсөн Крымын хойгийн асуудал, Украины зүүн өмнөд хэсэг дэхь зөрчил, иргэний дайны улмаас ОХУ болон АНУ, Европын Холбооны хоорондын харилцаа эрс хүйтэрч, тэдний зүгээс Оросын эсрэг хориг арга хэмжээг шат дараалан авч эхлэв. Харин ОХУ-н байр суурь төдийлөн өөрчлөгдсөнгүй, хориг арга хэмжээний хариуд эдгээр орнуудаас импортоор авдаг зарим төрлийн хүнсний бүтээгдэхүүнд хориг тавьж, 2014 оны 7 дугаар сараас дэлхийн зах зээл дахь газрын тосны бүтээгдэхүүний үнийн бууралт, түүнээс улбаатай рублийн ханшны сулрал, төсвийн алдагдал зэргээс шалтгаалан Оросын эдийн засаг хямралын байдалд шилжив. Крымын хойгийг иргэдийнх нь санал асуулгын дүнгээр ОХУ өөрийн мэдэлд авч, түүнийг ОХУ-н бүрэлдэхүүн субъектийн хувьд нэмж санхүүжүүлэхэд 25 тэрбум еврог зарцуулсан нь төсөвт төлөвлөгдөөгүй хүндрэлийг авчирсан.

2014 оноос Оросын эдийн засагт дараах хандлагууд илэрч эхлэв. Үүнд:

- Нөөц хумигдсаны улмаас хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан
- Хүн амын орлогын өсөлтийн хурд саарснаас хэрэглээний өсөлт багассан
- Хадгаламжийн бүтэц өөрчлөгдсөн
- Экспортын өсөлт саарч, хөрөнгийн гадагши урсгал эрчимжиж, төлбөрийн чадварын тогтвортой байдал буурсан
- Хэрэглээний инфляци эрчимжсэн
- Эдийн засгийн бүтэц аажмаар муудсан

Учир нь эдийн засгийн либералчлал дуусаагүй, түүхий эдийг экспортлох загварт тулгуурласан өрөөсгөл эдийн засгийн бүтэц нь

түүхий эдийг боловсруулан худалдах салбаруудад ашигтай байж, харин түүхий эдийн борлуулалттай холбоогүй салбарууд байнга алдагдал хүлээх болов. Зарим тоон үзүүлэлтийг дурьдвал:

- 2014 оны эхнээс инфляци 9.1 хувиар өсөж, бараа бүтээгдэхүүний үнэ 8.5 хувиар нэмэгдсэн ба будаа, шошны үнэ 15 хувиар, сахар, ногоо, жимсний үнэ 8.1-8.5 хувиар тус тус өсжээ. Үүнд, 2014 оны хоёрдугаар хагаст рубль суларч, барууны орнуудын хоригийн эсрэг тавьсан хүнсний бүтээгдэхүүний хориг, гурвалжин будааны ургац буурсан зэрэг онцлог шалтгаанууд нөлөөлсөн.

- АНУ, ЕХ болон Австрали, Шинэ Зеланд, Канад, Япон зэрэг орнуудын эдийн засгийн хориг 2015 онд үргэлжилвэл ОХУ-ын жилийн төсөвт 40 тэрбум ам.долларын алдагдал гарна, харин газрын тосны бүтээгдэхүүний үнэ 60 -70 ам (өмнө нь 100 орчим ам доллар байсан)долларт хүрч унавал төсвийн орлого жилдээ 90-100 тэрбум ам. долларын алдагдал хүлээнэ гэж ОХУ-н Сангийн сайд Антон Силуанов 2014 оны 11 дүгээр сард мэдэгдсэн. Учир нь 2015 оны Холбооны төсөв дэлхийн зах зээл дээр “Урал” маркийн нэг баррель газрын тосны үнэ 103 ам доллар байхаар тооцоолж хийгдсэн бөгөөд харин 2015 оны бодит амьдрал дээр тэр нь 50-60 ам долларын хооронд хэлбэлзэж байна. Тэрээр “Төсөв хумигдах нь зайлшгүй. Хэрэглээг өргөжүүлэх байдлаар эдийн засгийн өсөлтөө хангах бус харин дотоод зах зээлд илүүтэй тулгуурлаж, хадгаламжийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Удаан хугацааны нөөцийг бий болгох, үүнд тэтгэврийн хуримтлал, амь насны даатгалын хадгаламж хамаарах ба банкуудыг бэхжүүлэх нь нэн чухал. Бид бүх хүчээ дайчлан, өмнө нь хүндрэлээс нь төвөгшөөн авч хэрэгжүүлж чадаагүй шийдвэрүүдээ гаргах цаг ирлээ. Бид бүсээ чангалан эдийн засгийн шинэ парадигмын нөхцөлд амьдарч сурах хэрэгтэй болсон” гэж “Глобальчлалын савлагааны үеийн Оросын эдийн засгийн бодлого” сэдэвт эдийн засгийн чуулган дээр/2014.11.24/ хэлсэн байдаг. ОХУ-ын Төв Банк 2014 оны 11 дүгээр сарын 10-д байнгын тогтмол интервенцийг халж, рублийг чөлөөтэй хөвөх горимд шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Бодлогын хүүг 12 дугаар сарын 10-нд 9.5-10.5 хувь болгож нэмсэн. 1 долларын ханш 80 рубль, 1 еврогийнх 100 рубльд хүрч, нэг баррель газрын тосны үнэ 50 ам.доллар болсон

“хар Мягмар гариг” буюу 2014 оны 12 дугаар сарын 16 ны өдөр Төв Банк бодлогын хүүгээ 17 хувь болгож огцом нэмсэн. Харин 2015 он гарснаар бодлогын хүүг нэгдүгээр сарын 31-д хоёр пунктээр бууруулж 15 хувь, 2 дугаар сард дахин нэг пунктээр доошлуулж 14 хувь болгосон. Мөн 2015 оны 4 дүгээр сарын 29-ны өдрөөс 12.5 хувь болгон дахин бууруулсан. Учир нь бодлогын хүү өндөр байх нь бизнесийн орчинд сөрөг нөлөөтэй байдаг.

1999-2007 онд Оросын эдийн засгийн өсөлт 6-7 хувьтай байсан бол 2012-2013 онд жилд 1.5-2 хувь болж буурсан. Дэлхийн Банк энэ оны хавар хэвлүүлсэн “Global Economic Prospects” илтгэлдээ 2015 онд ОХУ-ын ДНБ-ий өсөлт хасах 2.7 хувь, 2016 онд нэмэх 0.7 хувь, 2017 онд 2.5 хувьтай байна гэж тооцоолон гаргажээ. Оросын эдийн засагт илэрч буй хямралын байдалд барууны орнуудын хориг, газрын тосны дэлхийн зах зээл дахь үнийн өөрчлөлт, дэлхийн зах зээл дахь ам.долларын өсөлт нь Оросын рублийн ханшийг сулруулахад давхар нөлөөлж, Украины зүүн өмнөт хэсэгт болж буй дайнд ОХУ их бага ямар нэгэн хэмжээгээр (хүмүүнлэгийн тусламж) үзүүлэн татагдан оролцож байгаа зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байна. Түүнчлэн дээр дурьдсан 2012-2013 оноос ажиглагдсан эдийн засгийн өсөлтийн бууралт нь Оросын эдийн засгийн хөгжлийн өрөөсгөл загвараас үүдэлтэй.

2015 оны хямралыг 1998 оны болон 2008 оны хямралтай харьцуулах нь аргачлалын хувьд буруу гэж зарим шинжээчид үздэг. Тухайлбал 2008 оны дэлхийн санхүүгийн хямралын үед дэлхийн зах зээл дээр газрын тос, байгалийн хий болон бусад түүхий эдийн үнэ өсөж байсан бол 2015 оны хямрал нь эсрэгээр эдгээр бүтээгдэхүүний үнийн уналтаас үүдэн бий болж байна. 1998 оны эдийн засгийн хямрал нь санхүүгийн систем нурж рубль үнэгүйдэж, Засгийн газрын богино хугацаатай үнэт цаасны хувьцааны хямрал зэрэг дотоод шалтгаанаас үүдэлтэй байв. Харин 2008 оны хямрал нь гадаад хүчин зүйл, тухайлбал АНУ-ын орон сууцны ипотекийн зээлээс шалтгаалан банкны сектор дампуурснаас дэлхий нийтийг хамарсан санхүү-эдийн засгийн хямрал болон даамжирсан. Энэ хямрал Орост яаж илэрсэн бэ? Гадны санхүү валютын хөрөнгө оруулалт буурч, дэлхийн хөрөнгө оруулалтын урсгалын чиглэл өөрчлөгдсөн. / Ж:үнэт цаас, акци - хувьцаагаар хийх

шаардлага дэвшигдсэн/, Оросын хөрөнгийн зах зээлийг дэлхийн хөрөнгийн зах зээлийн хандлага өөрчлөлтэд нийцүүлэн боловсронгуй болгох, рублийг чөлөөтэй хөвөх системд шилжүүлэх, мөнгөний хэрэгцээг валютын интервенци хийхээс илүүтэй банкуудыг дахин санхүүжүүлэх хэлбэрт шилжүүлэх, хэрэглээний зээлийн идэвхтэй өсөлтийг хангах, хүнсний бүтээгдэхүүний волатильность нэмэгдэх, дотоод хэрэгцээ хумигдах зэрэг нөхцөл хүндрэлийг дагуулсан. Тиймээс 2008 оны хямралын дараа Оросын нийгэмд эдийн засгийн хөгжлийн загварыг эрс өөрчлөх, цогц шинэчлэл хийх хэлэлцүүлэг 2009 оны туршид хүчтэй өрнөсөн.Түүхий эдээ (байгалийн хий, нефть бүтээгдэхүүн) экспортлох замаар төсвөө бүрдүүлэх нь ирээдүй муутай тул дотоод зах зээлийг баримжаалсан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах хөгжлийн шинэ загварт шилжих нь зүйтэй гэдэг дээр санал төвлөрсөн.

Эдийн засгийн хөгжлийн шинэ загварыг төлөвшүүлэхэд дараах зорилтуудыг хэрэгжүүлэх шаардлагатай гэж судлаачид² бичиж байна. Үүнд :

- түүхий эдийн бус, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн шинэ салбарыг хөгжүүлэх
- идэвхтэй хөрөнгө оруулалтын бодлого явуулах
- үйлдвэрлэл технологийн аппаратыг үндсээр нь шинэчлэх, инновацид тулгуурласан бодлогыг хэрэгжүүлэх
- төсвийн бодлогоо эрс шинэчлэх, мөнгөний бодлогоо зах зээлийн зарчимд нийцүүлэн өөрчлөх
- бизнесийн орчныг тааламжтай болгон өөрчлөх, хувийн хэвшлийн үйл ажиллагааг бүхий л талаар хөхиүлэх
- хөдөлмөрийн зах зээлийг либералчилж, түүний үр ашгийг нэмэгдүүлэх

- хүний нөөцийн капиталыг зөв бэлтгэн хуваарилж ашиглах

2. В.Мау “Экономика и политика в 2011 году: глобальный кризис и поиск новой модели роста”. Журн. “Вопросы экономики” №2,2012
Г.Клейнер “Какая экономика нужна России и для чего”. Журн. “Вопросы экономики” №3,2013
Б.Замараев, А.Киоцевская, А.Назарова, Е.Суханов. “Замедление экономического роста в России”. Журн. “Вопросы экономики” №8,2013

- эдийн засаг нээлттэй байж, чөлөөт өрсөлдөөнийг өрнүүлэх зэрэг алхмуудыг онцолж байна.

2008 оны хямралын үед дэлхийн зах зээл дахь газрын тос, металлын үнэ тогтворжсон явдал нь таваарын зах зээл хурдан өөрчлөгдөж хэвийн болоход нөлөөлсөн тал бий. Эдийн засгийн үзүүлэлт сайжирлаа гэж үзэн Оросын төр засаг, бизнесийнхэн санаа амарч, цогц шинэчлэлийн зорилтыг хэрэгжүүлээгүй орхисон.

Харин 2015 оны хямралын шалтгаанд Оросын эдийн засгийн өсөлтийн хурд аажмаар саарсан, инфляцийн хэлбэлзлийг буруу тооцсон, газрын тосны зах зээл дахь үнийн дайн /үүнд АНУ, Их Британи, Франц зэрэг хүчирхэг улсуудын удирдагч нарын улс төрийн амбици буюу XIX болон XX зуунд “алдагдсан байр сууриа” эргүүлэн авах гэсэн эрмэлзлийг хэлж байна / зэрэг хүчин зүйлийг нэрлэж байна.

2008-2009 оны оны хямралын дараа Оросын эдийн засгийн хөгжлийн өрөөсгөл загварыг халах, эрс шинэчлэл хийх талаар дорвитой ажил хийгдээгүйн хор уршиг нь ийнхүү эдийн засгийн өсөлт эргээд буурах, дэлхийн зах зээлийн түүхий эдийн үнээс хамааралтай төсөв бүрдүүлэлт хүндэрмэгц хямралт байдалд эргэн орсон.

Дэлхийн эдийн засгийн форум болох Давосын чуулганд /2015 оны 2 дугаар сар/ оролцсон ОХУ-ын Засгийн газрын орлогч Игорь Шувалов: Оросын эдийн засаг хямралын нөхцөлд байгааг тэмдэглэж, эрс шинэчлэл, либералчлалын алхам шаардагдаж буйг хүлээн зөвшөөрсөн. Түүхий эдийн бус салбарын үйлдвэрлэл, экспорт болон дотоодын зах зээлд илүүтэй түшиглэсэн үйлдвэрийн салбарыг дэмжих, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх салбарыг хөгжүүлэх зорилт тулгарч байна гэдгийг тэрээр хэлсэн. Мөн хямралын байдалд түргэн дасан зохицох, байдлыг бодитой үнэлж дүгнэх шаардлагатайг тэмдэглээд хямрал нь бас боломж байдаг тул цаг алдалгүй зөв алхмуудыг хэрэгжүүлнэ гэж хэлсэн.

2014 оны 12 дугаар сард ОХУ-ын Засгийн газар хямралын эсрэг төлөвлөгөөг Төрийн Думаар батлуулан ажиллаж байна. Газрын тосны борлуулалтаас хараат байдаг улсын төсвийн бүрдүүлэлт тасарч, 2015 оноос зайлшгүй хэрэгцээт зардлыг Улсын Нөөцийн Сангаас гаргахаар

тогтов.Төрийн өмчийн томоохон үйлдвэрүүдэд Холбооны төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлж байна. Арилжааны банкуудыг дахин санхүүжүүлэх замаар ялангуяа хүнсний бүтээгдэхүүний(тахиа,гахайн мах, өндөг, сүү г.м) импортыг орлох ЖДҮ-д дэмжлэг илүүтэй үзүүлэх болов. Нийгмийн салбарын санхүүжилтийг танахгүйгээр цалин тэтгэвэр тэтгэмжийг индексжүүлэн бууруулахгүй байх, ажлын байрыг хадгалах зарчмын байр суурийг баримталж байна. Хүүхдийн цэцэрлэг нэмж барихад хөрөнгө оруулалт хийх, ажилгүйдлийг нэмэгдүүлэхгүй тогтвортой түвшинд барих зорилтыг дэвшүүлсэн. 2008-2009 оны хямралын үед ажилгүйдлийн түвшин 9 гаруй хувьтай байсан бол 2015 онд ажилгүйдлийн түвшин 5.9 хувьтай байна. Ажлаас халагдах явдлаас урьдчилан сэргийлэх зорилготой 18 тусгай хөтөлбөр хэрэгжүүлж, түүний санхүүжилтэнд 20 тэрбум рублийг Холбооны төсвөөс зарцуулж байна. Богино хэмжээний сургалт, шинэ мэргэшил эзэмшүүлэх сургалт, түр ажлын байр бий болгох зэрэг олон чиглэлийн арга хэмжээг эдгээр хөтөлбөрүүдэд тусгажээ. (Гэвч үүнийг ашиггүй ажлын байрыг удаан хадгалж, бага цалинтай хүмүүсийг ажилтай мэтээр удаан байлгах нь эдийн засгийн үр өгөөж муутай гэж либерал эдийн засагчид шүүмжилж байна.Учир нь улсын төсвийн зардлыг бууруулахад хөдөлмөрийн харилцааны хууль тогтоомжийн шинэчлэл зайлшгүй хэрэгтэй юм). ОХУ-ын Төрийн Дум 2014 оны сүүлчээр иргэдийн банкин дахь хадгаламжийн баталгааг 1.4 тэрбум рубль болгон нэмэгдүүлэх шийдвэрийг гаргасан.

ОХУ нь 2020 он хүртэлхи нийгэм эдийн засгийн урт хугацааны хөгжлийн Стратегийн баримт бичигт тулгуурлан 2010 онд ОХУ-ын 2020 он хүртэлхи Инновацийн хөгжлийн Стратегийг боловсруулан хэрэгжүүлж байна. Хямралын нөхцөлд төсөв хүнрэлтэй байгаа ч үйлдвэрлэл технологийн шинэ парк, кластерийг хөгжүүлэхэд тодорхой хэмжээний хөрөнгийг зарцуулсаар байна. Мөн “ОХУ-н нийгэм-эдийн засгийн эн тэргүүнд хөгжүүлэх нутаг дэвсгэрийн тухай” хуулийг 2014 онд батлан, үүнд Алс Дорнодыг хамруулан гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих орчныг бүрдүүлэхэд онцгой анхаарч байна. 2012 онд Алс Дорнодын Хөгжлийн Яамыг байгуулсан. Дорнод Сибирь, Номхон далайн газрын тос дамжуулах хоолойг 2014 онд хоёр үе шаттайгаар барьж дуусгасан бөгөөд эдүгээ Зүүн Сибирьт ”Сила

Сибири” дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалтыг өрнүүлж байна. Учир нь ОХУ-ын түлш эрчим хүчний нөөцийн ихэнхи хэсэг нь Зүүн Сибирь, Алс Дорнодод байдаг.

ОХУ нь эдийн засгийн гадаад хамтын ажиллагаанд чухал ач холбогдол өгч, АНУ, ЕХ-ны зүгээс хориг арга хэмжээ авсан цаг үеэс шинэ түншүүдийг эрэлхийлэх, хамтран ажиллах олон гэрээ хэлэлцээрүүдийг цаг алдалгүй байгуулаад байна. Тухайлбал, БНХАУ, Турк Улсад газрын тосны бүтээгдэхүүнийг худалдахаар тохиролцож, хэлэлцээр байгуулсан. БНАСАУ-тай хамтран Хасан-Ражин боомтоор газрын тос экспортлохоор яриа хэлэлцээ хийгдсэн. Аргентин Улстай цөмийн эрчим хүчний салбарт хамтран ажиллахаар тохиролцсон. Ийнхүү гадаад худалдааны түншүүдийн тоог нэмснээр эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжоо өргөтгөх нөхцлийг бүрдүүлж байгаа нь Оросыг ганцаардуулах гэсэн барууны орнуудын бодлогыг сөрж буй идэвхтэй алхам гэж харагдаж байна. Энэ нь 2015 оны 7 дугаар сард Башкирийн Уфа хотод болсон ШХАБ, БРИКС-ийн орнуудын дээд удирдлагын ээлжит уулзалтын үеэр тодорхой илэрсэн. ШХАБ-ын жинхэнэ гишүүнээр ОХУ-ын худалдаа-эдийн засгийн идэвхтэй түнш Энэтхэг, Пакистан Улс элсэж, БРИКС-ийн удирдлагууд өнгөрсөн жилийн зунаас ярьсан Хөгжлийн Банкнийг 5 орон тус бүр ижил хэмжээний хөрөнгө гаргаж БНХАУ-ын Шанхай хотноо төвлөрүүлэн байгуулахаар тохиролцов. Энэ Банкны үйл ажиллагаа 2016 оны эхнээс жигдэрнэ гэж ярьж байгаа бөгөөд БРИКС-ийн гишүүн 5 оронд хөрөнгө оруулалт хийх, мөн хөгжиж буй орнуудад хөгжлийн тусламж, зээл олгох зэрэгт чиглэгдэнэ. Энд нэг зүйлийн тэмдэглэхэд, ОХУ-ын валютын нөөц одоо 363 тэрбум ам.доллар байгаа бөгөөд ойрын 5 жилд уг нөөцийн хэмжээг 500 тэрбумд хүргэх зорилготой байна. Учир нь Крымыг 2014 оны 3 сард ОХУ-д нэгтгэхээс өмнө ийм хэмжээний нөөцтэй байсан. Тиймээс дээрхи Банкны үйл ажиллагааны нэг чиглэл үүнд ашигтай байх талтай. Мөн БРИКС-ийн удирдлагууд (ОХУ, БНХАУ, Бразили, Энэтхэг, Өмнөт Африк) ОУВС-ийн явуулж буй үйл ажиллагаанд шүүмжлэлтэй ханддаг ба хөгжиж буй орнуудад үзүүлж буй зээл тусламж нь шударга бус гэж хэлсэн удаатай. Магадгүй энэ утгаар ДБ, ОУВСантай өрсөлдөхүйц Хөгжлийн хамтарсан Банкны суурийг тавьж, хөгжиж буй орнуудыг өөрийн талд

татах ирээдүйн зорилгын нэг хэрэгсэл болгож байгаа болов уу гэсэн судлаачийн таамгийг дэвшүүлж байна.

“Импортозамещение” буюу импортыг орлох арга хэмжээг хэрэгжүүлэн, гадаадаас худалдан авдаг хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх, үндэсний үйлдвэрлэл, ялангуяа хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, үүнд 20 тэрбум рублийн нэмэлт санхүүжилтийг хуваарилав. Ялангуяа мал аж ахуй, газар тариалан, ногоо жимс, сүү, сүүн бүтээгдэхүүнийг орчин үеийн дэвшилтэт аргаар боловсруулах үйлдвэрүүдэд хөрөнгө оруулалт хийх, техник технологийн шинэчлэлд энэхүү хөрөнгийг зарцуулж байна.

Эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдлаас гарах гарцыг 2 хувилбараар Оросын эрдэмтэд авч үзэж байна³. Консерватив болон Либерал хувилбарын аль нэгийг сонгох чухал эргэлтийн үед Оросын эдийн засаг тулж ирлээ.

Консерватив хувилбар луу хэлбийх хандлага илэрч буйд зарим судлаачид, өмнө нь ЗГ-т өндөр алба хашиж байсан зүтгэлтнүүд сэтгэл зовнин саналаа хэлж байна. Учир нь Оросын дотоод бодлогод эрх чөлөөг хязгаарлах, иргэний болон улс төрийн эрхийг хумих хандлага нилээд ажиглагдах болов. Жишээлбэл: хууль сахиулах болон хяналтын байгууллагуудын байр суурь хүчирхэгжиж, төвлөрөл улам гүнзгийрч, “төлөвлөлтийн” гар удирдлагын практик хэрэгжих болов. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр консерватив үнэлэмжийг түлхүү сурталчилж байна. Батлан хамгаалах цогцолборын үүрэг роль өсөн нэмэгдэж, энэ нь гадаад улс төрийн түншүүдийг сонгох улс төрийн гол үүдлэг /мотивация/ болж хувирав. Засгийн газраас инфляцийг хязгаарлахад чиглэсэн мөнгө-зээлийн хатуу бодлого явуулж байна. Харин эдийн засгийн идэвхийг дэмжих гол арга нь бүс нутгийн түвшинд хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах явдал юм. Түүхий эдэд түшиглэсэн хөгжлийн загварыг ирээдүйд хэвээр нь хадгалвал нийгэмд орлогын тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлж, “оюуны алдалт”(утечка мозгов)-д хүргэх сөрөг үр дагавартай. Тиймээс одоогийн ЗГ-с

3. Н.Акиндинова,Я.Кузьминов,Е.Ясин “Российская экономика на повороте” журн.”Вопросы экономики” №6,2014

хэрэгжүүлж буй эдийн засгийг эрчимжүүлэх цогц арга хэмжээний төлөвлөгөө нь эдийн засгийн сэргэлтийн түр зуурын хурдцыг л хангаж чадна. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн өсөлтийг 1-2 жилд 2.0-2.5 хувийн түвшинд хүчээр барих явдлаас хэтрэхгүй. Тиймээс тодорхой зорилго чиглэлгүй, төлөвлөгөөгүй төсвийн болон мөнгө-зээлийн бодлогыг явуулах нь төсвийн алдагдлыг бууруулахгүй, өсөн нэмэгдэж буй инфляци хяналтаас гарах аюулд хүргэнэ гэж тэд үзэж байна. Эдийн засаг хаалттай байгаа үед хүчээр хэрэгжүүлж буй импортыг орлох арга хэмжээ нь өрсөлдөөн хангалтгүй орчинд үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний дундаж чанарыг сулруулж, үйлдвэрлэгчдийн өртөг нэмэгдэх хор уршгийг дагуулах магадлалтай.

Харин Либерал загварыг сонговол дараах алхмуудыг хэрэгжүүлэх болно. Үүнд:

- сэргөлдөх, хорих бодлого баримтлах практикаас татгалзаж, удирдлагын төвлөрлийг сааруулна
- нийгэм ба бизнест үзүүлж буй хүч хэрэглэсэн дарамтыг багасгана
- авлигыг бууруулах талаар хүчтэй тэмцэл хийнэ
- өрсөлдөөнийг дэмжих ба хувийн өмчийг хөхиүлэх, энэ нь үйлдвэрлэлийн хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх хөшүүрэг болно.
- хувийн хөрөнгө оруулалтанд илүүтэй түшиглэх замаар хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт болон хүний нөөцийн капиталын хүчин зүйлд түшиглэнэ. Ингэснээр инфляцийг хөөрөгдүүлэхгүйгээр эдийн засгийн өсөлтийн хурд тогтвортой нэмэгдэх суурь нөхцөл бүрдэнэ.

Хамгийн чухал нь эдгээр өөрчлөлтийг хийх нийгмийн хэрэгцээ шаардлага бүрэлдсэн байх явдал юм. Либерал загварт болгоомжлонгуй хандах үзэл хандлага Оросын нийгэмд байна. Энэ нь ч шинэхэн үеийн түүхийн сургамжтай холбоотой. 1992-1998 оны шилжилтийн үед Егор Гайдар тэргүүтэй ОХУ-н Засгийн газар нь Дэлхийн Банк, ОУВС-н заавар, Джефри Сакс, Андерс Ослунд зэрэг гадны зөвлөгчдийн удирдлаган дор төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг зах зээлийн

зарчимд шилжүүлэх “цочир эмчилгээний” шинэчлэлийг (үүнд: бүх нийтийн хүч түрж хийсэн хувьчлал, нэг удаагийн дайралтын үнэ чөлөөлөлт, мөнгө-зээлийн хатуу бодлого)⁴ ганц далайлтаар хэрэгжүүлсэн нь зэрлэг капитализмын шинж тэмдэг болох нийгмийн ядуурлыг бий болгон, хууль зөрчих явдал гаарах, олигархиуд төрөх, гэмт хэрэг нэмэгдэх, авлига бий болох, эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухааны салбар эрс уналтанд орох, нийгмийн ёс зүй-зан суртахуун доройтоход хүргэсэн. Улсын төвлөрсөн монополийг задлах энэхүү үйл явцыг зарим улс төрчид, судлаачид зайлшгүй хийх ёстой алхам гэж үздэг бол нөгөө хэсэг нь бүхнийг нэг дор нураалгүйгээр алгуур шинэчлэл хийх боломж Оросын нийгэмд бүрэн нээлттэй байсан гэж үздэг хүмүүс саналаа илэрхийлсээр байна.

Харин өнөөдөр Сангийн сайд асан Алексей Кудрины санал болгосноор Төрийн Думын сонгууль цаашлаад ОХУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн товыг наашлуульж хийвэл В.В.Путин сонгогчдын итгэл мандатыг өвөрлөн эдийн засгийн эрс шинэчлэлийг хэрэгжүүлэх дотоод тогтвортой нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна. Либерал загварыг дэмжиж буй эрдэмтэд тухайлбал, А.Кудрин, С.Алексащенко, Е.Гурвич, Е.Ясин, С.Гуриев зэрэг бусад хүмүүс 2015 оны 6 сард болсон Санкт-Петербургийн олон улсын эдийн засгийн чуулганы өмнө болон чуулганы үер эдийн засгийн шинэчлэлийг яаралтай хийх командыг В.Путин ОХУ-ын Засгийн газарт өгөх хэрэгтэй гэсэн саналыг хэлсэн. Учир нь эдүгээ Путины нэр хүнд Орост өндөр байгаа энэ байдлыг тэд ашиглахыг хүсэж байгаа нь ойлгомжтой. Гэвч барууны Хэвлэл мэдээллийн хэрэгсэл тухайлбал, Bloomberg TV Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль ойртох тусам Путин эрс шийдэмгий алхам хийхээс зайлсхийнэ. Оросын эдийн засаг цаашид хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлаж чадахаа болисон гэдэг саналыг илэрхийлж байна. ОХУ-ын Статистикийн Газрын мэдээгээр, 2015 оны 5 сард иргэдийн бодит орлого жилийн дунджаар тооцоолсноор 6.4 хувиар буурсан байна. 2015 оны 6 сарын эхээр Е.Гайдарын нэрэмжит Эдийн засгийн бодлогын хүрээлэнгээс бэлтгэн гаргасан илтгэлийн эмхэтгэлд: Оросуудын

4. А.В.Кива “Российские реформы в контексте мирового опыта. Вопросы теории и политической практики”. Институт востоковедения РАН, 2006, с.136

бодит орлого, цалин багассанаар хэрэглээний эрэлт үргэлжлэн буурч, үйлдвэрлэгчдэд дэмжлэг үзүүлэхээ болив. Хэрэглээ хумигдах нь үйлдвэрлэлийн хэмжээ багасах, улмаар хүн амын орлого буурахад нөлөөлж, хэрэглээний шинэ бууралтыг өдөөж байна гэж бичжээ.

Хувь судлаачийн хувьд өнөөдөр Оросын эдийн засагт шаардагдаж буй Либералчлалын алхмууд нь 90-ээд оны зорилтоос эрс өөр агуулгатай гэдгийг тэмдэглэхийн сацуу түүнийг хэрэгжүүлэхгүй дахин хойш тавибал Орос орны хувьд хүчирхэг эдийн засагтай, дундаж болон түүнээс дээш түвшний хүн амын орлоготой эрчимтэй хөгжсөн, орчин үеийн улс байх зорилт улам холдох ирээдүй хүлээж байгааг хэлэе.

ДҮГНЭЛТ

1. ОХУ-д эдийн засгийн цогц шинэчлэл хэрэгжих, эдийн засгийн шинэ загварыг бий болгох үйл явц нилээн удаан хугацаанд, дотоод улс төрийн болон гадаад ээдрээтэй нөхцөлд, өөрийн гэсэн онцлогтойгоор хэрэгжих болов уу гэсэн таамгийг судлаачийн хувьд дэвшүүлж байна.

2. ОХУ-ын ЗГ-н гишүүдийн хэлж ярьсан зүйлээс харахад хямралыг намжаах түр зуурын арга хэмжээнээс илүүтэй хүндрэл бэрхшээлтэй ч гэсэн зайлшгүй хийх ёстой бодлогын томоохон зорилт, шийдвэрийг гаргах хэрэгтэй гэдэг нэгдмэл саналтай байна. Гагцхүү шинэчлэл эхлүүлэх улс төрийн шийдвэрийг Ерөнхийлөгчийн зүгээс гарахыг хүлээж буй болов уу.

3. ОХУ-н Ерөнхийлөгч В.В.Путины ард түмэндээ хандаж хийдэг ээлжит хэвлэлийн бага хурал /2014.12.14/ дээр эдийн засгийн хямралт байдлаас гарах гарцын тухай ярихдаа:”Амьдрал өөрөө эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийхийг шаардаж байна” гэж хэлсэн удаатай. 2015 оны 6 сард болсон Санкт-Петербургийн олон улсын эдийн засгийн чуулган дээр бизнесийн хүрээнийхэнд хандан тэрээр Оросын үйлдвэрүүдийн өрсөлдөх чадварыг сулруулахад хүргэж буй рублийн ханш хэт чанга байх явдлыг хазаарлах болно гэж амласан бөгөөд “зах зээлийн харилцааны хүрээн дэх зохицуулалт нь манай үйлдвэрлэгчдийн эрх ашгийг хамгаалж хангахад чиглэгдэнэ” гэж үүнийгээ тодруулжээ.

4. В.В.Путины нэр хүнд удирдагчийн хувьд дотооддоо болон гадаадад өндөр байгаа өнөөдрийн нөхцөлд эдийн засгийн

либералчлалын алхмуудыг зоригтой хэрэгжүүлэх дотоод зайлшгүй нөхцөл, гадаад талын нэг талын шахалт дарамт, нөгөө талын ашигтай боломжийн аль аль нь бүрдсэн гэж судлаачийн хувиар харж байна. Энэхүү боломжийг үл ашиглах аваас эдийн засгийн илүү эрчимтэй, ирээдүйтэй гарц харагдахгүй байгаа юм. Мэдээж Оросын иргэдэд шинэчлэл хэрэгжүүлэх явцад амаргүй хүндрэлийг даван туулах, эрсдэлтэй тулгарах нөхцөл бий болно. Гэвч үүнээс өөр зам байхгүй гэдгийг дэлхийн бусад орны туршлага нэгэнтээ харуулжээ.

НОМ ЗҮЙ

1. А.В.Кива. “Российские реформы в контексте мирового опыта. Вопросы теории и политической практики” Институт востоковедения РАН, 2006
2. В.Мау. “Экономика и политика в 2011 году: глобальный кризис и поиск новой модели роста”. журнал “Вопросы экономики” №2, 2012
3. Б.Замараев. А.Киуцевская, А.Назарова, Е.Суханов.”Замедление экономического роста в России”. журн. ”Вопросы экономики”. №8, 2013
4. Г.Клейнер. “Какая экономика нужна России и для чего”. Журнал “Вопросы экономики”, №3, 2013
5. С.Глазьев. “Санкции США и политика Банка России” журн.”Вопросы экономики”, №9, 2014
6. Ж.Орхон. Дорнод Сибирь-Номхон далай газрын тос дамжуулах хоолой. “Олон улс судлал” сэтгүүл 2011, №1
7. Ж.Орхон. ОХУ-ын Инновацийн хөгжлийн стратеги: агуулга болон хэрэгжүүлэх арга зам. “Олон улс судлал” сэтгүүл 2011, №3
8. Опрос хэл дээрх Интернет эх сурвалж: www.economy.gov.ru;
9. www.gazeta.ru; www.yandex.ru; www.touch.news.mail.ru